



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2013 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А1548

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн Хүүхдийн найрал дууны  
шилдэг хамтлаг шалгаруулах уралдаант  
наадам зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5а, 29.2, 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 44 дүгээр тогтоол, 2008 оны 2/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн ивээл дор зохион байгуулагддаг Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин Дагвын Лувсаншаравын нэрэмжит "Хүүхдийн найрал дууны шилдэг хамтлаг" шалгаруулах 21 дэх удаагийн уралдаанд оролцох дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудын бэлтгэл, зохион байгуулалтыг хангаж, анхан шатны шалгаруулалтыг зохион байгуулсугай.

2. Уралдаан, наадмын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, анхан шатны шалгаруулалтад шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Уралдаанд дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудыг бүрэн хамруулж, амжилттай зохион байгуулахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс /П.Ганбат/-т даалгасугай.

4. Анхан шатны шалгаруулалтын үйл ажиллагаанд зарцуулагдах 4,330,000 /дөрвөн сая гурван зуун гучин мянган/ төгрөгийг Засаг даргын Тамгын газрын төвлөрсөн арга хэмжээний зардлаас гаргахыг Тамгын газар /Т.Нямцэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ОРОСОО

Заавал дуулах дууг Уралдааныг Зохион байгуулагчид сонгон, сургалт явуулах бөгөөд өөрийн сонголтоор дуулах дан найрал дууг хөгжмийн багш найруулга хийж оролцоно.

#### **Тав. Шүүгчдийн комисс**

Уралдааныг мэргэжлийн эрдэмтэн багш нар, уран бүтээлчид дүгнэнэ.

#### **Зургаа. Шагнал урамшуулал**

Уралдаанд оролцох хамтлаг, багшийг:

1. Дууны сонголт
2. Найруулга
3. Найрал дуучдын болон хормейстр багшийн ур чадвар
4. Тайзны соёл, хувцаслалт
5. Эрэгтэй эмэгтэй хүүхдийн тооны харьцааг шийдвэрлэсэн байдал /Оролцох хамтлаг 60-аас дээш хүний бүрэлдэхүүнтэй байх/
6. Бэлтгэл зохион байгуулалт зэрэг шалгуураар дүгнэж дараах байр эзлүүлэн шагнаж урамшуулна.

#### ***I шатны шалгаруулалт: (дүүргийн хэмжээнд)***

Тэргүүн байр	1	Өргөмжлөл	мөнгөн шагнал
Дэд байр	1	Өргөмжлөл	мөнгөн шагнал
Гуравдугаар байр	1	Өргөмжлөл	мөнгөн шагнал
Тусгай байр	1	Өргөмжлөл	мөнгөн шагнал
Шилдэг удирдаач багш	1	Өргөмжлөл	мөнгөн шагнал
Шилдэг найруулга	1	Өргөмжлөл	мөнгөн шагнал



Баянгол дүүргийн Засаг даргын 2013  
оны 09 сарын 20-ны өдрийн А/598  
захирамжийн нэгдүгээр хавсралт

**Д.ЛУВСАНШАРАВЫН НЭРЭМЖИТ ХҮҮХДИЙН НАЙРАЛ  
ДУУНЫ ШИЛДЭГ ХАМТЛАГ ШАЛГАРУУЛАХ 21 ДЭХ  
УДААГИЙН УРАЛДААНТ НААДМЫН УДИРДАМЖ**

Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулиудын хөгжмийн хичээлийн сургалтыг чанаржуулж өсвөр үеийнхэнд уран сайхны боловсрол олгох, гоо зүйн хүмүүжлийг төлөвшүүлэх, хүүхэд бүрийн авьяасыг хөгжүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын ивээл дор уламжлал болон зохиогддог Монгол улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин Дагвын Лувсаншаравын нэрэмжит Хүүхдийн найрал дууны шилдэг хамтлаг шалгаруулах уралдаант наадмыг хоёр үе шаттайгаар зохион явуулж байна.

**Нэг. Наадмын зорилго**

Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулиудын хөгжмийн хичээлийн сургалтыг чанаржуулж өсвөр үеийнхэнд уран сайхны боловсрол олгох, гоо зүйн хүмүүжлийг төлөвшүүлэх, хүүхэд бүрийн авьяасыг хөгжүүлэх зорилготой болно.

**Хоёр. Хамрах хүрээ**

Баянгол дүүргийн Ерөнхий боловсролын төрийн болон төрийн бус өмчийн бүх сургуулиуд хамрагдана.

**Гурав. Уралдааны шалгаруулалт**

Уг уралдаан нь 2 үе шаттай явагдах бөгөөд эхний шатны шалгаруулалтанд дүүргийн бүх сургуулиуд хамтлагаараа оролцож, эхний 3 байр эзэлсэн хамтлагууд хоёрдугаар шатны шалгаруулалтанд нийслэлийн бусад дүүргээс шалгарсан найрал дууны хамтлагуудтай өрсөлдөх болно.

**I. Шатны шалгаруулалт:** 2013.10.10-ны өдөр 10.00 цагт МҮЭСТОрдонд болно.

**II. Шатны шалгаруулалт:** 2013.10.23-ны өдөр Монголын хүүхдийн ордонд болно.

Хоёрдугаар шатны шалгаруулалтанд амжилттай оролцсон сургуулиудын найрал дууны хамтлагийг Нийслэлийн өдрийн хүндэтгэлийн тоглолтод оролцуулж тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулна. Хүндэтгэлийн тоглолт "Соёлын төв өргөө"-нд 2013 оны 10 дугаар сарын 29-нд болно.

**Дөрөв. Уралдаанд тавигдах шаардлага**

Уралдаант наадамд найрал дууны хамтлагууд өндөр ур чадвар шаардсан нийт 3 дуугаар оролцоно. Үүнд:

а/ Заавал дуулах дуу

б/ Өөрийн урын санд шинээр орсон дан найрал дуу

в/ Хөгжимтэй найрал дууны бүтээл